



НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг
эрчимжүүлэх аян зохион байгуулах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3,1 дэх заалтыг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Шийдвэр гүйцэтгэгч ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэх зорилгоор 5,0 сая хүртэлх үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгох 17 хоногийн аяныг удирдамжийн дагуу зохион байгуулсугай.

2. Аяныг 2015 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 09:00 цагаас 03 дугаар сарын 31-ний өдрийн 17:00 цаг хүртэлх хугацаанд зарласугай.

3. Аяны хугацаанд хамгийн олон гүйцэтгэх баримт бичиг дуусгавар болгож тэргүүлсэн нэг шийдвэр гүйцэтгэгч, нийт дүнгээр дүүрэг нь хамгийн олон гүйцэтгэх баримт бичиг дуусгавар болгосон дүүргийн ахлах шийдвэр гүйцэтгэгч, энэ хугацаанд хамгийн их төлбөр төлбөр төлөгчийг эрэн сурвалжлан олсон эрэн сурвалжлах хэсгийн нэг ажилтан, бүх үзүүлэлтээрээ бусдыгаа хошуучилсан Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан хэсгийн нэг шийдвэр гүйцэтгэгчийг тус тус шагнаж урамшуулна.

4. Аяны хугацаанд шийдвэр гүйцэтгэгч нарын шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж, үнэн зөв дүгнэж ажиллахыг ахлах шийдвэр гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

5. Хэсгүүдийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавьж, биелэлтийг 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 17:00 цагт нэгтгэн дүгнэж, 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 08:30 цагт албаны даргад илтгэх хуудсаар танилцуулахыг дэд дарга, /дэд хурандаа Ч.Оюунцэцэг, хошууч Ж.Нандинтуул/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Т.ЭНХБАТ

1120150000061
2015 tushaal

БАТЛАВ: ДАРГА,
ДЭД ХУРАНДАА  Т.ЭНХБАТ

“БАГА ҮНИЙН ДҮНТЭЙ ГҮЙЦЭТГЭХ БАРИМТ БИЧГИЙН
БОДИТ БИЕЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ” ЗОРИЛГООР
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЯНЫ УДИРДАМЖ

2015.03.13

Улаанбаатар хот

Нэг.Аяны зорилго

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2015 оны зорилтын нэг болох “Нэг ч иргэнийг гомдоохгүй ажиллах зорилт”-ыг хангах зорилгоор албаны хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж буй бага үнийн дүнтэй түдгэлзүүлсэн болон ажиллагаатай гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг нэмэгдүүлж, гар дээр байх гүйцэтгэх баримт бичгийн тоог бууруулахад аяны зорилго оршино.

Хоёр.Аяны хугацаа

Аяныг 2015 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 09:00 цагаас 03 дугаар сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэлх 17 хоногийн хугацаанд зохион байгуулж 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдөр нэгтгэн дүгнэж, 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр тэргүүлсэн албан хаагчийг шагнаж урамшуулна.

Гурав. Аяны болзол

Аяны хугацаанд гүйцэтгэх баримт бичгийг бүрэн гүйцэт хааж дуусгавар болгосон байх ба уг баримт бичгийг цахим бүртгэлд нэг бүрчлэн иж бүрэн шивж бүртгэсэн байна.

Дуусгавар болгосон гүйцэтгэх баримт бичгийг тухай бүр тоо бүртгэлийн ажилтан, ахлах дэслэгч Б.Баасанхандад бүртгүүлж мэдээлэлд оруулсан байх.

Дөрөв. Шагнал урамшуулал

Аяны хугацаанд тэргүүлж хамгийн их гүйцэтгэх баримт бичиг дуусгавар болгосон нэг шийдвэр гүйцэтгэгчийг “IPHONE-6” гар утсаар, дүүрэг нь хамгийн их гүйцэтгэх баримт бичиг дуусгавар болгосон нэг ахлах шийдвэр гүйцэтгэгчийг “Сарын үндсэн цалингаар”, хамгийн их төлбөр төлөгчийг олж шийдвэр гүйцэтгэгчид хүлээлгэн өгсөн эрэн сурвалжлах хэсгийн нэг ажилтныг “Сарын үндсэн цалингийн 50 хувиар”, бүх үзүүлэлтээрээ бусдыгаа хошуучилж ажилласан Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан хэсгийн нэг шийдвэр гүйцэтгэгчийг “Сарын үндсэн цалингаар” тус тус шагнаж урамшуулна.